



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

### 「 Спортын тэмцээн зохион байгуулах тухай 」

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/88 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн газрын дүрэм”-ийн 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Улаанбаатар марафон”-д нэгдэцгээе Нийслэлийн Засаг даргын нэрэмжит цом аялуулах аяны хүрээнд Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 97 жилийн ойн арга хэмжээг угтсан нийтийн тээврийн салбарын аварга шалгаруулах спортын тэмцээний удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, тус тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Уг тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрүүдэд өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг /З.Цэвээндорж/-т даалгасугай.


3.Тэмцээнд ажилтан албан хаагчдаа идэвх санаачилгатай хамруулахыг нийтийн тээврийн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийтийн тээврийн газрын даргын  
2022 оны 05 дугаар сарын 24 ны  
өдрийн 4/32 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН САЛБАРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “СПОРТЫН ТЭМЦЭЭН”-ИЙ УДИРДАМЖ

### НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийтийн тээврийн салбарын хамт олны эв нэгдлийг сайжруулах, биеийн тамир спортоор хичээллэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, шилдэг баг тамирчдыг шалгаруулах зорилгоор салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд спортын аварга шалгаруулах тэмцээнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахад оршино.

### ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, ЯВАГДАХ ХУГАЦАА

2.1.Тэмцээнийг нийслэл хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд болон салбарын холбогдох байгууллагуудын дунд 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 25-ны өдрийн хооронд спортын 7 төрлөөр зохион байгуулна.

Д/д	Спортын төрөл	Оролцох тамирчид	Хугацаа	Зохион байгуулагдах газар
1	Шатар	1 эр, 1 эм	2022.06.22	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
2	Ширээний теннис	1 эр, 1 эм ,	2022.06.22	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
3	Дартс	4 эр, 2 эм	2022.06.22	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
4	Хөл бөмбөг	12 эр 1 дасгалжуулагч	2022.06.22 2022.06.23	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
5	Биллиард	Удирдлага	2022.06.25	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
6	Волейбол	10 эр, 10 эм 1,1 дасгалжуулагч	2022.06.22- 2022.06.24	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ
7	Сагсан бөмбөг	9 эр, 9 эм 1,1 дасгалжуулагч	2022.06.23- 2022.06.25	Техникийн зөвлөгөөн дээр мэдээлнэ

2.2.Тэмцээнд нийслэл хотын хэмжээнд нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд болон салбарын холбогдох байгууллагуудын үндсэн ажилчид оролцоно. Үүнд:

#### 2.2.1.Заавал оролцох байгууллагууд

- Нийтийн тээврийн газар
- Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд

- Улаанбаатар смарт карт ХХК
- 2.2.2.Урилгаар оролцох байгууллагууд
- Зам, тээврийн хөгжлийн яам,
- Салбарын төсөл хэрэгжүүлэгч нэгж,
- Том оврын автобусны үйлчилгээ эрхлэгчдийн холбоо,
- Такси үйлчилгээ эрхлэгчдийн холбоо,
- Салбарын бусад байгууллага.

## **ГУРАВ.ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГУУДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1.Тэмцээнд аж ахуйн нэгж, байгууллагуудаас эрэгтэй, эмэгтэй баг оролцоно.

3.2.Оролцогч багууд сагсан бөмбөгийн төрөлд 9, волейболын төрөлд 10 хүний бүрэлдэхүүнтэй эрэгтэй, эмэгтэй баг, хөл бөмбөгийн төрөлд 12 хүний бүрэлдэхүүнтэй эрэгтэй баг, дартсын төрөлд 6 хүний бүрэлдэхүүнтэй /4 эрэгтэй, 2 эмэгтэй/ холимог бүрдүүлнэ. Шатар, ширээний теннисний төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 тамирчин, биллиардын тэмцээнд тухайн байгууллагын удирдлага /дарга, захирал/ оролцоно.

3.3.Багийн бүрэлдэхүүнд оролцогч тамирчин нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх ба 3 сараас доошгүй хугацаанд ажилласан байх шаардлагатай. /Гэрээт ажилтан орохгүй, ажилтны сарын цалингийн доод хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй байна./

3.4.Тэмцээний нээлтийн ажиллагаа 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 11:00 цагт болох бөгөөд нээлт хаалтын ажиллагаанд байгууллагын нэр бичсэн туг далбаатай жагсаж, тамирчид хувийн дугаар бүхий жигд хувцастай оролцоно.

3.5.Тэмцээнд оролцох аж ахуйн нэгж, байгууллагууд нь баг, тамирчдын албан ёсны мэдүүлэг /тамирчны зураг бүхий/, 2 хувь зураг, Иргэний үнэмлэхийн хуулбар, ажлын үнэмлэхийн хуулбар, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа авч ирж бүртгүүлнэ. Мэдүүлэгт тамирчны регистрийн дугаарыг заавал тусгасан байна. Тэмцээнд оролцохдоо иргэний үнэмлэхийг заавал авч ирнэ.

3.6. Тэмцээнд оролцохоор хуурамч материал бүрдүүлсэн, тэмцээний үеэр мэдүүлэгт тусгагдаж, мандат олгосон тамирчнаас өөр тамирчин оролцуулсан тохиолдолд тухайн багийг тухайн төрлийн тэмцээнээс шууд хасна.

3.7.Тэмцээнд оролцогч багийн тооноос хамаарч оноо, хугацаа, тоглолтын систем, зохион байгуулалтын бусад асуудлыг техникийн зөвлөгөөнөөр эцэслэн шийдвэрлэнэ. Сугалаа сугалснаас хойш тэмцээнд оролцох баг, тамирчдын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй. Шаардлагатай тохиолдолд баг тус бүрийн тамирчдын бичиг баримтыг лавлан шалгах бөгөөд бичиг баримтын зөрчил гаргасан багийг тэмцээнээс шууд хасна.

3.8.Тэмцээн эхлэх цагийг хатуу баримтлах бөгөөд тоглолт эхлэх цаг зарласнаас 5 минут хоцорсон тохиолдолд хоцорсон буюу ирээгүй багийг хожигдсоноор тооцож дараагийн тоглолтыг эхлүүлнэ.

3.9.Уг тэмцээний талбайн шүүгч зөвхөн тоглолттой холбоотой асуудлыг шийдэх ба бусад маргаантай асуудлыг зөвхөн багийн ахлагчаар дамжуулан ерөнхий шүүгч болон зохион байгуулагчдад тавьж шийдвэрлүүлнэ.

3.10.Оролцогч байгууллагууд ажилтан албан хаагч, хөгжөөн дэмжигчдээ идэвх санаачилгатай, соёлтой оролцуулна.

## **ДӨРӨВ. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН**

4.1. Техникийн зөвлөгөөн 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 14.00 цагт Нийтийн тээврийн газрын уулзалтын танхимд болно.

4.2. Техникийн зөвлөгөөн дээр тэмцээнийг зохион явуулах дүрэм, журмыг танилцуулж, багуудын сугалааг хийнэ.

4.3. Тэмцээний зохион байгуулалтын зардал, аж ахуйн нэгж, байгууллагуудын тэмцээний хураамжийг оролцогчдын тооноос хамаарч ажлын хэсгээр хэлэлцэж, шийдвэрлэнэ.

4.4. Техникийн зөвлөгөөн дээр багийн мэдүүлгийг хянаж, мандат олгох хуваарийг ААНБ бүрээр танилцуулж, 2022 оны 06 дугаар сарын 7, 9-ний өдрүүдэд мандат олгоно. Хуваарьт хугацаанд шаардлага хангаагүй материал ирүүлсэн болон материал дутуу байсан тамирчдад мандат нөхөж олгохгүй.

4.5. Зөвхөн ганцаарчилсан төрөлд оролцох эсвэл 2.2.1-д заасан байгууллагууд оролцох боломжгүй тохиолдолд ажлын хэсгээр хэлэлцэж, шийдвэрлэсэн дүнгээр шагналын санг тодорхой хэмжээгээр бүрдүүлнэ.

## **ТАВ. ТЭМЦЭЭНИЙГ ДҮГНЭХ ЖУРАМ**

5.1. Тэмцээний төрөл тус бүрд эрэгтэй, эмэгтэй 1-ээс 3 дугаар байр эзлүүлнэ.

5.2. Тэмцээнийг их онооны системээр дүгнэн “ШИЛДЭГ БАГ”-ийг шалгаруулна.

Тэмцээний 7 төрөл тус бүрд байр эзэлсэн баг, тамирчдыг их онооны системээр дараах оноогоор дүгнэнэ. Үүнд:

Багийн төрөлд:

1-дүгээр байр : 12 оноо

2-дугаар байр: 11 оноо

3-дугаар байр: 10 оноо

4-дүгээр байр: 9 оноо

5-8 дугаар байр: 8 оноо

Хэсгээсээ шалгарч чадаагүй тохиолдолд: 5 оноо

Ганцаарчилсан төрөлд

1-дүгээр байр : 8 оноо

2-дугаар байр: 7 оноо

3-дугаар байр: 6 оноо

4-дүгээр байр: 5 оноо

5-8 дугаар байр: 4 оноо


Хэсгээсээ шалгарч чадаагүй тохиолдолд: 2 оноо

5.3. Оноо тэнцвэл нийт багийн алтан медалийн чанарыг харгалзан үзнэ.

## **ЗУРГАА. ШАГНАЛ**

Тэмцээн төрөл бүр 1-ээс 3 дугаар байр эзлүүлж алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно. Мөнгөн шагналын хэмжээг ажлын хэсгээс тогтооно.

Нийтийн тээврийн газрын даргын  
2022 оны 05 дугаар сарын 18 ний  
өдрийн 430 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:	
З.Цэвээндорж	Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	
Б.Дөлгөөн	Зорчигч, тээврийн үйлчилгээний хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч
Б.Баярмаа	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч
А.Оргилсайхан	Хүний нөөцийн хариуцсан ахлах мэргэжилтэн
Б.Солонгосайхан	Тээвэр зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
Э.Энхтөр	Хуулийн зөвлөх
О.Сүхбаатар	Автотээврийн хяналтын улсын байцаагч
Б.Бадамдорж	Ажлын гүйцэтгэлийн хяналтын мэргэжилтэн
Ч.Бадамханд	Салбарын сургалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
М.Батцэцэг	График, зогсоол, чиглэлийн мэдээллийн сан хариуцсан ажилтан
Ч.Чагнаадорж	Техникийн хяналтын үзлэгийн инженер
Б.Даваадолгор	Судалгаа шинжилгээний мэргэжилтэн
Д.Мөнхцэцэг	Эмч
Ө.Цэндмаа	Тооцооны нягтлан бодогч
Б.Ариун-Эрдэнэ	Жолооч
Ц.Мягмарсүрэн	Улаанбаатар смарт карт ХХК-ийн менежер /зөвшилцсөнөөр/
Н.Мөнхжаргал	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-ын биеийн тамирын аргазүйч /зөвшилцсөнөөр/

Д.Мөнхтулга	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн ахлах инженер /зөвшилцсөнөөр/
Э.Бат-Оргил	Тэнүүн-Огоо ХХК-ийн Ашиглалтын албаны дарга /зөвшилцсөнөөр/
Ө.Очироо	Эрдэм транс ХХК-ийн тээвэрлэлт, үйлчилгээ хариуцсан захирал /зөвшилцсөнөөр/
н.Төгсжаргал	Улаанбаатар такси транспорт ХХК-ийн менежер /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Г.Даваадулам	Эдийн засаг, төсвийн мэргэжилтэн
Б.Бэхбол	Автотээврийн хяналтын улсын байцаагч